



# planetGOLD-ийн Байгаль орчин, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагааны шалгуур

Шалгуурын тухай мэдээлэл болон Маягт

Бичил уурхайн байгууллагын нэр

Огноо

Улс, аймаг, сум, баг

Тайлан гаргагчийн овог, нэр

Хувилбар 1.0

## Агуулга

|      |  |    |
|------|--|----|
| I.   | Ерөнхий мэдээлэл.....  | 3  |
| II.  | planetGOLD шалгуур .....   | 3  |
|      | Шалгуур үзүүлэлт А: Мөнгөн усгүй хүдэр баяжуулалт ба Химийн бодис, хог хаягдлын менежмент (цианид, мөнгөн ус агуулсан хаягдал).....            | 3  |
|      | Шалгуур үзүүлэлт В: Уугуул иргэдийн амьдрал ба эрхийг хүндэтгэх.....   | 4  |
|      | Шалгуур үзүүлэлт С: Байгаль орчныг хамгаалах .....   | 6  |
| III. | planetGOLD шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах маягт .....  | 8  |
|      | planetGOLD шалгуурыг хангахын төлөө тууштай ажиллах тухай мэдэгдэл .....   | 8  |
|      | Шалгуур үзүүлэлт А: Хүдрийг мөнгөн усгүй технологиор баяжуулах, химийн бодис, хаягдлын менежмент (цианид, мөнгөн усаар бохирдсон хаягдал)..... | 9  |
|      | Шалгуур үзүүлэлт В: Уугуул иргэдийн амьдрал ба эрхийг хүндэтгэх.....   | 10 |
|      | Шалгуур үзүүлэлт С: Байгаль орчныг хамгаалах .....   | 13 |
| IV.  | Мэдэгдлийг баталгаажуулж гарын үсэг зурах .....  | 18 |
|      | ХАВСРАЛТ I: Эрсдэл ба эрсдлийг бууруулах төлөвлөгөө .....  | 19 |
|      | ХАВСРАЛТ II: Зөвлөж буй хавсралтуудын жагсаалт .....   | 20 |
|      | ХАВСРАЛТ III: Уугуул иргэдийг хүндэтгэх тухай мэдэгдэл.....  | 21 |

## I. Ерөнхий мэдээлэл

planetGOLD хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй төслүүд нь Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцийн шаардлага болон Байгаль орчин, нийгмийн хамгааллын талаарх Даян дэлхийн байгаль орчны сан (ДДБОС)-ийн бодлоготой нийцсэн байх ёстой. Тиймээс, planetGOLD хөтөлбөрийн бичил уурхайн байгууллага (БУБ)<sup>1</sup>-ууд нь КРАФТ Код-ын 1-4-р модулийн шаардлагыг хангахаас гадна уг хөтөлбөрт хамаарах дараах гурван нэмэлт шалгуурыг хангах ёстой.

- ✓ Шалгуур үзүүлэлт А: Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцын хавсралт С-ийн зорилгод нийцүүлэн олборлолтын явц дахь мөнгөн усны хэрэглээг зогсоож, мөнгөн усаар бохирдсон хаягдлын менежментийг зохих ёсоор хэрэгжүүлэх;
- ✓ Шалгуур үзүүлэлт В: ДДБОС-ийн байгаль орчин, нийгмийн хамгааллын шаардлагад нийцүүлэн уугуул иргэдийн эрхийг хүндэтгэж, хамгаалах; мөн
- ✓ Шалгуур үзүүлэлт С: Биологийн төрөл зүйл, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахад онцгой анхаарал хандуулж, ДДБОС-аас шаардсан байгаль орчныг хамгаалах нэмэлт асуудлуудыг тусган биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг багасгах.

Бүх шалгуурыг хангасан бичил уурхайн байгууллагыг стандартын шаардлагыг зохих ёсоор хангасан гэж үзэх бөгөөд хариуцлагатай худалдан авагчидтай хамтарч ажиллахад бэлэн болсон гэж тооцно.

Дараах тохиолдолд бичил уурхайн байгууллагыг тодорхой болзолтойгоор шалгуурыг хангасан гэж үзэх бөгөөд хариуцлагатай худалдан авагчидтай харилцах, хамтран ажиллах боломжтой. Үүнд:

- Бичил уурхайн байгууллага нь хамгийн багадаа planetGOLD шалгуур (А) болон КРАФТ Кодын Модуль 1, 2, 3-д тодорхойлсон шаардлагыг бүрэн хангасан байх, мөн
- planetGOLD-ын В, С шалгуурууд болон КРАФТ Кодын Модуль 4-ийн хувьд бүрэн шийдвэрлэгдээгүй эрсдэл тодорхойлогдсон тохиолдолд бичил уурхайн байгууллага эдгээр шалгуурыг хангах, эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрхэн ахиц дэвшил гарахыг тодорхой тусгасан төлөвлөгөө боловсруулж цаг хугацааны турш үйл явцын тасралтгүй ахиц дэвшлийг харуулна.

Эдгээр шалгуурыг боловсруулах болон дагаж мөрдөх, нийцүүлэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг planetGOLD Байгаль орчин, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагааны шалгуур бичиг баримтад агуулсан бөгөөд дараах холбоосоос үзнэ үү: [planetGOLD-ийн Байгаль орчин, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагааны шалгуур](#)

## II. planetGOLD шалгуур

Шалгуур үзүүлэлт А: Мөнгөн усгүй хүдэр баяжуулалт ба Химийн бодис, хог хаягдлын менежмент (цианид, мөнгөн ус агуулсан хаягдал)

Энэхүү шалгуур нь бүх Бичил уурхайн байгууллагууд үйл ажиллагаандаа мөнгөн ус ашиглахгүй байж, мөнгөн усны тухай Минаматагийн конвенцын хавсралт С-д (НҮББОХ 2013) заасны дагуу мөнгөн ус агуулсан хүдрийн хаягдлыг цианид ашиглан уусган баяжуулах хамгийн муу аргыг халахыг шаарддаг.

<sup>1</sup> Бичил уурхайн байгууллагад үндсэн болон шороон орд, уурхайн болон баяжуулалтын хаягдал овоолгоос хүдэр олборлох, ялгах, баяжуулах болон тээвэрлэх үйл ажиллагаанд оролцдог бүх бичил уурхайн байгууллагууд багтана. (ХБУХ. 2020. КРАФТ 2.0)

| Шалгуур үзүүлэлт   | Баталгаажуулах арга хэрэгсэл  |
|--|---|
| A1. Баяжуулах байгууламж нь мөнгөн уснаас ангид байна.   | Хүдэр баяжуулах байгууламжид мөнгөн ус ашигласан тухай ямар нэгэн ул мөр, нотлох баримт байхгүй байх.   |
| A2. Мөнгөн усаар өмнө нь амальгам хийсэн бөгөөд урьдчилан мөнгөн усыг нь бүрэн гүйцэд ялгаагүй баяжмал, хүдэр болон баяжмалын хаягдлыг цианидаар уусган баяжуулаагүй байна. <sup>2</sup> | Баяжуулах цех/байгууламжууд нь мөнгөн усаар бохирдсон хаягдлыг дахин цианидаар уусган баяжуулдаггүй, эсвэл бусад хаягдлыг цианид ашиглан уусган баяжуулагчдад мөнгөн усаар бохирдсон хаягдлыг эхлээд мөнгөн усыг цэвэрлэлгүйгээр худалддаггүй гэдгээ нотлох баримтаар хангах; ЭСВЭЛ мөнгөн усаар бохирдсон хаягдлыг цианидаар уусган баяжуулдаг цех/байгууламжууд нь хаягдлыг цаашид боловсруулах, худалдах, хаяхаасаа өмнө мөнгөн усыг цэвэршүүлсэн (мөн мөнгөн усны байгаль орчинд ээлтэй зохицуулалт хийх) тухай нотлох баримтыг өгөх. |

Шалгуур үзүүлэлт В: Уугуул иргэдийн амьдрал ба эрхийг хүндэтгэх

Энэхүү шалгуур нь уул уурхайн төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны нөлөөнд өртөж болзошгүй уугуул иргэдийн хувь хүний болон хамт олны эрх, соёл, соёлын өвийн дурсгалт газрууд, дүр зураг, үзэл бодол, амьдралыг бичил уурхайн байгууллага хүндэтгэдэг байхыг шаарддаг.<sup>34</sup>

Тайлбар: Доорх planetGOLD шалгуур нь Чөлөөтэйгөөр урьдчилан мэдээлж зөвшилцөл (FPIC) хийх гэх мэт тус шалгуурыг хэрэгжүүлэх тодорхой арга хэрэгсэл нь тухайн улсын хууль тогтоомж, нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байж болохыг хүлээн зөвшөөрдөг.

| Шалгуур үзүүлэлт  | Баталгаажуулах арга хэрэгсэл  |
|---|---|
| B1. Бичил уурхайн байгууллага нь уугуул иргэдийн эрх, нутаг дэвсгэр, байгалийн баялаг, соёлын өвийг хүндэтгэх үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн олон нийтэд нээлттэй бодлогын баримт бичигтэй байна. <sup>5</sup> | Бичил уурхайн байгууллага нь уугуул иргэдийн эрх ашиг, тэдний нутаг дэвсгэр, байгалийн баялаг, соёлын өвийн дурсгалт газруудыг хүндэтгэх амлалтаа бичгээр олон нийтэд дэлгэж, бичил уурхайн үйл ажиллагааны нөлөөнд шууд болон шууд бусаар автаж буй уугуул иргэд энэ талаар мэдээлэлтэй байхыг баталгаажуулна. |

<sup>2</sup> Хавсралт С, догол мөр 1-ийг үзнэ үү (b) (iv) (Минаматагийн конвенц); 2В боть, Модуль 5, Хэсэг М.5/1.3.11/S.1.4 үзнэ үү (КРАФТ 2.0, 2020).

<sup>3</sup> [https://www.un.org/esa/socdev/unpfii/documents/UNDG\\_guidelines\\_EN.pdf](https://www.un.org/esa/socdev/unpfii/documents/UNDG_guidelines_EN.pdf)

<sup>4</sup> MS5: догол мөр 11, a-i (ДДБОС, 2018)

<sup>5</sup> Уугуул иргэдийн эрхийн талаарх Нэгдсэн үндэстний байгууллагын тунхаглал. Дараах холбоосоос үзнэ үү: [www.un.org/esa/socdev/unpfii/documents/DRIPS\\_en.pdf](http://www.un.org/esa/socdev/unpfii/documents/DRIPS_en.pdf)

|   |   |
|---|---|
| <p>В2. Бичил уурхайн байгууллага өөрийн олборлолтын үйл ажиллагаа болон уурхайчдын нөлөөнд шууд болон шууд бусаар автаж болзошгүй уугуул иргэд байгаа эсэхийг тодорхойлсон байна.</p>   | <p>Бичил уурхайн байгууллага нь:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Нөлөөнд өртөж болзошгүй уугуул иргэдийг тодорхойлоход туслах зорилгоор зөвлөлдсөн хүмүүс болон ашигласан бусад арга хэрэгслүүдийн тодорхойлолтыг өгнө.</li> <li>2. Ийм нөлөөлөлд өртсөн иргэдийг төлөөлөх этгээдийг оролцуулах төлөвлөгөөг бичгээр боловсруулан өгнө.</li> </ol>   |
| <p>В3. Бичил уурхайн байгууллага нь:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Уул уурхайн үйл ажиллагаанаас гарч болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлохын тулд нөлөөлөлд өртсөн уугуул иргэдэд тэдний ёс заншлыг хүндэтгэсэн арга барилаар хүрч ажиллана. Ийм нөлөөлөл нь дараах байдлаар тохиолдож болно: <ol style="list-style-type: none"> <li>а) Уламжлалт өмчлөл/өв уламжилсан буюу ёс заншлын дагуу ашиглагдаж байгаа байгалийн баялгийг ашиглах эрхийг хязгаарлах, эсхүл тухайн газар дээрх төсөл, хөтөлбөрийн байршил, байгалийн баялгийг арилжааны зориулалтаар хөгжүүлэх эрхийг хязгаарлах;</li> <li>б) Уламжлалт өмчлөлд хамаарах газар, байгалийн баялгаас нүүлгэн шилжүүлэх, эсвэл уламжлалт ашиглалт, эзэмшил газар; болон</li> <li>с) Соёлын өвийг уул уурхайн зориулалтаар ашиглах болон ноцтой нөлөө үзүүлэх.<sup>6</sup></li> </ol> </li> <li>2. Уугуул иргэдтэй хамтран ажиллаж: <ol style="list-style-type: none"> <li>а. Төсөл эхлүүлэх зөвшөөрөл авч, тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах; ЭСВЭЛ</li> <li>б. Хэрэв уугуул иргэд төсөл эхлүүлэх хүсэлтийг хүлээн авахгүй, татгалзах эсвэл нэмэлт мэдээлэл, тодруулга авах хүртэл хойшлуулахаар шийдвэрлэсэн бол тэдний шийдвэрийг хүндэтгэх.</li> </ol> </li> </ol> | <p>Бичил уурхайн байгууллага нь:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Уугуул иргэдийг бүрэн төлөөлөх байгууллага болон бусад хэлбэрийн зөвлөлдөх уулзалтын баримт бичгийг бүрдүүлж, үйл ажиллагааг танилцуулах, хэлэлцэх, бүрэн төлөөллийн байгууллагаас тавьсан асуултад хариулна;</li> <li>2. Болзошгүй нөлөөллийг тодорхойлоход ашигласан арга хэрэгслийн тодорхойлолтыг өгнө;</li> <li>3. Боломжит эерэг болон сөрөг нөлөөллийн талаар тайлан гаргах; болон</li> <li>4. Сөрөг нөлөөллийг бууруулах тухай нотлох баримтыг гаргаж өгнө.</li> </ol> |

<sup>6</sup> MS5: догол мөр.10, а-с (ДДБОС, 2018)

## Шалгуур үзүүлэлт С: Байгаль орчныг хамгаалах

Энэхүү шалгуур нь бичил уурхайн байгууллагаас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулах, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн аргыг ашиглахыг шаарддаг. Хариуцлагатай бичил уурхайн байгууллагууд байгаль орчныг нөхөн сэргээхэд тавигдах шаардлагуудыг багтаасан улс орныхоо байгаль орчны хууль тогтоомжийг дагаж мөрдөх; зайлшгүй сөрөг нөлөөллийг бууруулах; мөн ургамал, амьтны биологийн төрөл зүйлийг хамгаалах системтэй байна.

| Шалгуур үзүүлэлт  | Баталгаажуулах арга хэрэгсэл  |
|---|---|
| <p>C1. Бичил уурхайн байгууллага нь байгаль орчныг хамгаалах талаарх бүх хууль эрх зүйн орчин, шаардлагыг судалж, дагаж мөрдөх бөгөөд байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч тусгай хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахаас аль болох зайлсхийж ажиллана.</p>   | <p>Бичил уурхайн байгууллага нь:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тухайн улсын хууль дүрэм журмын дагуу олборлолтын тусгай эрх авах шаардлагатай бол тухайн эрхийг авсан байх, ЭСВЭЛ тухайн газрыг бичил уурхайн зориулалтаар ашиглахыг зөвшөөрсөн тухай бичиг баримт болон тэнд ажиллаж байгаа бичил уурхайчдын ажиллах зөвшөөрлийн бичиг бүрэн байх; мөн</li> <li>2. Усны бохирдлыг аль болох бага байлгах чиглэлээр ажилладаг байх, усны бохирдлын хяналтын төлөвлөгөө, тоо баримтыг үзүүлнэ.<sup>78</sup></li> <li>3. Байгаль орчны асуудал хариуцсан захиргааны байгууллагатай ажиллаж байгаа газрын биологийн төрөл зүйл, тогтцын талаар тодорхойлох чиглэлээр хамтарч ажиллана, эсвэл Биологийн төрөл зүйлийн нэгдсэн үнэлгээний [1] мэдээллийг ашиглаж олборлолтын газрын биологийн тогтцын талаарх үнэлгээ хийсэн байна; мөн</li> <li>4. Бичил уурхайн үйл ажиллагаа дууссаны дараа олборлосон газрыг нөхөн сэргээх төлөвлөгөөг гаргаж өгнө.</li> </ol> |
| <p>C2. [Зөвхөн тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий одоо ажиллаж байгаа байгууламжид хамаарна.]<br/>Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнийг сольж өөр газар ажиллах боломжгүй бол олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч ажиллана. Мөн түүнчлэн байгаль орчинд нөлөөлөх бусад</p> | <p>Бичил уурхайн байгууллагууд дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Олборлолтын тусгай зөвшөөрөл/лиценз эсвэл газрын зөвшөөрөлтэй байх;</li> <li>2. Байгаль орчныг хамгаалах холбогдох байгууллагатай хамтран дараах төлөвлөгөөг боловсруулсан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Олборлолтын үйл ажиллагаанаас хүрээлэн байгаа орчин болон усны эх үүсвэрт үзүүлэх нөлөөг бууруулах</li> </ul> </li> </ol>  |

<sup>7</sup> Хүдрийн хаягдал, химийн бодис болон шатахууны үлдэгдлээс бусад ус ашиглагчдад учруулж байгаа нөлөөг үнэлсэн байна. Өндөр эрсдэл бүхий ашигласан усны бохирдлыг хянадаг байх. Бохирдол бууруулах техникийн шинэчлэлийг дэвшүүлж хэрэгжүүлсэн байх. Усны чанар бусад ус хэрэглэгчдийн эрүүл мэнд болон экосистемийн ноцтой эрсдэлийн шалтгаан болохгүй байх ( Vol 4, Sec. 2.5.4, M.5/4.2.2/R.1 үзэх, CRAFT 2.0, 2020)

<sup>8</sup> Боть 4, Хэсэг 2.5.4, M.5/4.2.2/R.1, КРАФТ 2.0, 2020; MS7 (ДДБОС, 2018)

[1] <https://www.ibat-alliance.org/>

|   |  |
|---|--|
| <p>эрсдэлийг тодорхойлж үнэлгээ хийн бууруулах арга хэмжээ авсан байна.</p> | <p>төлөвлөгөө; болон</p> <ul style="list-style-type: none"><li>• Хүрээлэн байгаа орчны экосистем, биологийн төрөл зүйл, ойн санг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх тайлан бэлтгэсэн байна.</li></ul> |
|---|--|

### III. planetGOLD шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах маягт

#### Зааварчилгаа:

1. Бичил уурхайн байгууллага planetGOLD шалгуурыг дагаж мөрдөх тухай амлалтаа бичгээр илэрхийлнэ үү.
2. Шалгуур үзүүлэлт бүрийг уншсаны дараа Бичил уурхайн байгууллага шаардлага бүрд ямар түвшинд нийцэж/хангаж байгааг тодорхойлно. Тохирох хариултын хажууд (✓) тэмдэглэгээ хийнэ (биелсэн, ахицтай явагдаж байгаа, биелээгүй/амжилтгүй). Хариулт бүрд тайлбар хийх шаардлагатай.
3. Хэрэв шалгуур нь "хэрэгжиж буй" бол тохиролцоонд хүрэхийн тулд төлөвлөсөн нөлөөллийг бууруулах арга хэмжээнийхээ тайлбарыг Хавсралт I дахь загварт оруулна уу.
4. Баталгаажуулалтын нотлох баримт болох бичгэн мэдүүлэг, зөвшөөрөл, лиценз гэх мэт нэмэлт баримт бичгийг шаардлагын дагуу хавсаргана уу. Шалгуур тус бүрд шаардагдах баримт бичгийн жишээг Хавсралт II-оос үзнэ үү.

planetGOLD шалгуурыг хангахын төлөө тууштай ажиллах тухай мэдэгдэл

Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцийн дагуу алтны бичил уурхайн хүдэр баяжуулах үйл ажиллагаанд мөнгөн усны хэрэглээ, ялгарал болон өртөлтийг бууруулах, тэр дундаа мөнгөн усгүй хүдэр баяжуулах технологийг дэмжин, planetGOLD шалгуурыг дагаж мөрдөх үүрэг хүлээснээ тус бичил уурхайн байгууллага мэдэгдэж байна.

ГАРЫН ҮСЭГ

ОВОГ НЭР, АЛБАН ТУШААЛ, ҮНЭМЛЭХИЙН ДУГААР, ОГНОО

Шалгуур үзүүлэлт А: Хүдрийг мөнгөн усгүй технологиор баяжуулах, химийн бодис, хаягдлын менежмент (цианид, мөнгөн усаар бохирдсон хаягдал)

A1. Баяжуулах байгууламжууд нь мөнгөн уснаас ангид байна.

Шаардлагад нийцсэн байдлыг дараах байдлаар илэрхийлнэ:

|              |   |
|--------------|---|
| Биелсэн      | Бичил уурхайн байгууллага (БУБ) нь тэдний баяжуулах байгууламж нь мөнгөн ус хэрэглээгүй гэдгийг нотлох баримтаар харуулсан байна.     |
| Хэрэгжиж буй | Бичил уурхайн байгууллага хүдрээ мөнгөн усгүй баяжуулах арга технологид шилжих арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлж байна.                |
| Амжилтгүй    | Баяжуулах цех/байгууламж нь мөнгөн усгүй технологид шилжих төлөвлөгөө боловсруулаагүй бөгөөд мөнгөн усыг баяжуулалтад ашигладаг байх. |

A1. Танай байгууллага хүдэр боловсруулах үйл ажиллагаандаа мөнгөн ус ашигладаг уу?

Биелсэн

Хэрэгжиж  
буй

Амжилтгүй




Хариултаа энд тайлбарлаж бичнэ үү. Холбогдох нотлох баримтыг хавсаргана уу.

A2. Мөнгөн усаар өмнө нь амальгам хийсэн бөгөөд урьдчилан мөнгөн усыг нь бүрэн гүйцэд ялгаагүй баяжмал, хүдэр болон баяжмалын хаягдлыг цианидаар уусган баяжуулаагүй байна.

Шаардлагад нийцсэн байдлыг дараах байдлаар илэрхийлнэ:

|              |   |
|--------------|---|
| Биелсэн      | Бичил уурхайн байгууллага (БУБ) нь мөнгөн усаар бохирдсон хаягдлыг дахин цианидаар уусган баяжуулдаггүй, эсвэл бусад хаягдлыг цианид ашиглан уусган баяжуулагчдад мөнгөн усаар бохирдсон хаягдлыг эхлээд мөнгөн усыг цэвэрлэлгүйгээр худалддаггүй гэдгээ нотлох баримтуудыг гаргаж өгсөн байна. |
| Хэрэгжиж буй | Бичил уурхайн байгууллага мөнгөн усаар бохирдсон хаягдлыг дахин цианидаар уусган баяжуулахгүй байх арга хэмжээг төлөвлөж боловсруулж байгаа.  |
| Амжилтгүй    | Бичил уурхайн байгууллага нь мөнгөн усаар бохирдсон хог хаягдлыг цианидаар уусган дахин баяжуулдаг эсвэл мөнгөн усаар бохирдсон хаягдлаа  |

|  |   |
|--|---|
|  | цианидаар уусган баяжуулагчдад мөнгөн усыг нь эхлээд цэвэрлэхгүйгээр зардаг байх. |
|--|---|

A2. Танай цехэд мөнгөн усаар бохирдсон хаягдлыг цианидаар уусган баяжуулдаггүй, мөн/эсвэл мөнгөн усыг урьдчилан цэвэршүүлж, байгаль орчинд ээлтэй менежментийн арга хэмжээ авалгүйгээр ийм хаягдлыг цианидаар уусган баяжуулдаг цехэд худалддаггүйг нотлох баримтыг гаргаж өгч чадах уу? Хэрэв та өөрийн байгууламжид хаягдал боловсруулдаггүй бол Үгүй-г сонгоно уу.

Биелсэн                      Хэрэгжиж буй                      Амжилтгүй                      Хамаарахгүй

                                                                

Хариултаа энд тайлбарлаж бичнэ үү. Холбогдох нотлох баримтыг хавсаргана уу.

Шалгуур үзүүлэлт В: Уугуул иргэдийн амьдрал ба эрхийг хүндэтгэх

В1. Бичил уурхайн байгууллага нь уугуул иргэдийн эрх, нутаг дэвсгэр, байгалийн баялаг, соёлын өвийг хүндэтгэх үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн олон нийтэд нээлттэй бодлогын баримт бичигтэй байна.

Шаардлагад нийцсэн байдлыг дараах байдлаар илэрхийлнэ:

|              |   |
|--------------|---|
| Биелсэн      | Хүндэтгэх амлалтаа бичгээр олон нийтэд дэлгэж, уугуул иргэдийг төлөөлөгч бүх талууд энэ талаар мэдсэн байна.  |
| Хэрэгжиж буй | Уугуул иргэд, тэдний нутаг дэвсгэр, соёлын өвийг хүндэтгэх тухай амлалтыг бичгээр гаргахаар бэлтгэж байгаа бөгөөд уг мэдэгдлийг уугуул иргэд болон олон нийтэд нээлттэй мэдэгдэх/хуваалцах тодорхой төлөвлөгөө боловсруулсан байна. |
| Ахицгүй      | Ямар ч мэдэгдлийг бичгэн хэлбэрээр бэлтгээгүй байна.  |

**B1.** Уугуул иргэд, тэдний нутаг дэвсгэр, нөөц баялаг, соёлын өвийг хүндэтгэх тухай олон нийтэд нээлттэй бодлогын баримт бичгээ гаргаж өгч, уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд шууд болон шууд бусаар автсан уугуул иргэд энэхүү бодлогын талаар мэдэж байгаа гэдгийг баталж чадах уу?

Биелсэн

Хэрэгжиж  
буй

Биелээгүй

*Ийм мэдэгдэлгүй байж болзошгүй бичил уурхайн байгууллагад зориулсан мэдэгдлийн загварыг III ХАВСРАЛТААС харж болно. Хариултаа энд тайлбарлаж бичнэ үү. Холбогдох нотлох баримтыг хавсаргана уу.*

**B2.** Бичил уурхайн байгууллага өөрийн олборлолтын үйл ажиллагаа болон уурхайчдын нөлөөнд шууд болон шууд бусаар өртөж болзошгүй уугуул иргэд байгаа эсэхийг тодорхойлсон байна.

Шаардлагад нийцсэн байдлыг дараах байдлаар илэрхийлнэ:

|                     |   |
|---------------------|---|
| <b>Биелсэн</b>      | Олборлолтын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар өртөж болзошгүй уугуул иргэдийг тодорхойлох ажил хийгдэж, ийм нөлөөлөлд өртсөн иргэд, хамт олныг төлөөлөх байгууллагуудыг хэрхэн татан оролцуулах тухай төлөвлөгөөг бичгээр боловсруулж дууссан байна. |
| <b>Хэрэгжиж буй</b> | Шууд болон шууд нөлөөлөлд өртөж болзошгүй уугуул иргэдийг тодорхойлох ажил хийгдэж байгаа бөгөөд эдгээр нөлөөлөлд өртсөн иргэд, хамт олны төлөөллийн байгууллагуудыг татан оролцуулах тухай төлөвлөгөөг бичиж боловсруулж байна.                          |
| <b>Биелээгүй</b>    | Уул уурхайн болон/эсвэл уурхайчдын үйл ажиллагааны нөлөөнд шууд болон шууд бусаар өртөж болзошгүй уугуул иргэдийг тодорхойлоогүй байна.   |

**B2.** Уул уурхайн үйл ажиллагаа болон бичил уурхайчдын нөлөөнд шууд болон шууд бусаар өртөж болзошгүй уугуул иргэд байгаа эсэхийг тодорхойлсон уу? Ийм уугуул иргэд хаана байна бэ? Тэдэнтэй харилцах талаар боловсруулсан төлөвлөгөө байгаа юу?

Биелсэн

Хэрэгжиж  
буй

Биелээгүй

*Хариултаа энд тайлбарлана уу. Шаардлагатай тохиолдолд нөлөөнд өртөж болзошгүй уугуул иргэдийг тодорхойлох зорилгоор зөвлөлдсөн хүмүүсийн танилцуулга болон ашигласан*

аргуудыг тайлбарлана уу. Тэдэнтэй харилцах талаар боловсруулсан бичгэн төлөвлөгөө байгаа бол хавсаргана уу.

**B3.** Бичил уурхайн байгууллага нь уул уурхайн үйл ажиллагаанаас гарч болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлохын тулд нөлөөлөлд өртсөн уугуул иргэдэд тэдний ёс заншлыг хүндэтгэсэн арга барилаар хүрч ажиллана.

**\*\*Хэрэв энэ нь танай үйл ажиллагаанд хамаарахгүй бол "Үгүй" гэсэн хэсгийг бөглөөд С шалгуур үзүүлэлт руу шилжинэ үү\*\***

Шаардлагад нийцсэн байдлыг дараах байдлаар илэрхийлнэ:

|              |  |
|--------------|--|
| Биелсэн      | Уул уурхайн үйл ажиллагаанаас гарч болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлох, бууруулах зорилгоор нөлөөлөлд өртсөн уугуул иргэдэд тэдний ёс заншлыг хүндэтгэсэн арга барилаар хүрч ажилласан байна. |
| Хэрэгжиж буй | Хүрч ажиллах төлөвлөгөө гарсан ба/эсвэл хүрч ажиллах үйл ажиллагааг эхлүүлсэн, хийгдэж байна.  |
| Биелээгүй    | Ямар ч ажил хийж, хэрэгжүүлээгүй байна.  |

**B3.** Та уурхайн үйл ажиллагаанаас гарч болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг олж тогтоох, бууруулах зорилгоор нөлөөлөлд өртсөн уугуул иргэдэд тэдний ёс заншлыг хүндэтгэсэн арга барилаар хүрч ажилласан уу?

Биелсэн

Хэрэгжиж  
буй

Биелээгүй

Хамаарахгүй

Хариултаа энд тайлбарлана уу. Нөлөөллийг тодорхойлоход ашигласан аргачлалын тодорхойлолт, тодорхойлсон аливаа эерэг эсвэл сөрөг нөлөөллийн тайлан, сөрөг нөлөөллийг бууруулах нотлох баримт зэрэг энэхүү үйл ажиллагаатай холбоотой аливаа баримт бичгийг хавсаргана уу.

### Шалгуур үзүүлэлт С: Байгаль орчныг хамгаалах

С1. Бичил уурхайн байгууллагууд байгаль орчныг хамгаалах талаарх бүх хууль эрхзүйн орчин, шаардлагыг судалж дагаж мөрдөх бөгөөд байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч тусгай хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахаас аль болох зайлсхийж ажиллана.

Шаардлагад нийцсэн байдлыг дараах байдлаар илэрхийлнэ:

|              |   |
|--------------|---|
| Биелсэн      | Бичил уурхайн байгууллага нь байгаль орчны холбогдох бүх хууль тогтоомжийн шаардлагыг дагаж мөрдөн, бохирдлоос урьдчилан сэргийлэн ажилладаг бөгөөд тусгай хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулдаггүй байна.  |
| Хэрэгжиж буй | Бичил уурхайн байгууллага нь байгаль орчны бүх шаардлагыг хангах, бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, байгаль орчны шаардлагатай зөвшөөрлийг авах шатандаа явж байгаа бөгөөд тусгай хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахгүй байхыг зорьж байгаа. |
| Биелээгүй    | Бичил уурхайн байгууллага нь байгаль орчны зөвшөөрөлгүй, өргөдөл гаргаагүй, байгаль орчны хууль тогтоомжийн шаардлагыг дагаж мөрддөггүй, бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаггүй, эсвэл тусгай хамгаалалтын бүсэд ажилладаг байх.                     |

С1. Танай байгууллага үйл ажиллагаандаа байгаль орчны бүх хууль эрх зүйн шаардлагыг дагаж мөрддөг үү?

Биелсэн

Хэрэгжиж  
буй

Биелээгүй

Хариултаа энд тайлбарлана уу. Шаардлагатай бол зөвшөөрөл, лиценз, эсвэл тухайн газрыг бичил уурхайн зориулалтаар ашиглахыг зөвшөөрсөн тухай бичиг баримт болон тэнд ажиллаж байгаа бичил уурхайчдын ажиллах зөвшөөрлийн баримт бичгийг энэхүү бичиг баримтад хавсралтаар оруулна.

**C1a.** Танд усны хяналтын өгөгдөл эсвэл усны бохирдлыг хамгийн бага хэмжээнд барьж байгааг харуулах бусад нотлох баримт бий юу?

Биелсэн

Хэрэгжиж  
буй

Биелээгүй

*Хариултаа энд тайлбарлана уу. Шаардлагатай тохиолдолд усны хяналтын мэдээллийг энэхүү баримт бичгийн хавсралт болгон хавсаргана уу.*

**C1b.** Та тусгай хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхээ тодорхойлохын тулд байгаль орчны асуудал хариуцсан холбогдох байгууллагатай зөвлөлдсөн үү; эсвэл БТЗНУ<sup>9</sup> гэх мэт бусад холбогдох мэдээллийн сан таныг ийм газар ажиллаж байгаа эсэхийг тодорхойлох уу?

Биелсэн

Хэрэгжиж  
буй

Биелээгүй

<sup>9</sup> Биологийн төрөл зүйлийн нэгдсэн үнэлгээ ; <https://www.ibat-alliance.org/>

Хариултаа энд тайлбарлана уу.

C1c. Олборлолтын үйл ажиллагаа дууссаны дараа олборлосон газраа нөхөн сэргээх төлөвлөгөөгөө боловсруулсан уу?

Биелсэн

Хэрэгжиж  
буй

Биелээгүй

Хариултаа энд тайлбарлана уу. Шаардлагатай бол нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг энэ баримт бичгийн хавсралт болгон хавсаргана уу.

C2: [Зөвхөн тусгай хамгаалалтын бүсэд одоо зөвшөөрөлтэй ажиллаж байгаа цех/байгууламжид хамаарна]:

Тусгай хамгаалалтын бүсэд ажиллахаас зайлсхийх боломжгүй бол нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах ёстой. Бусад тодорхойлсон байгаль орчны эрсдэлийг мөн үнэлж, бууруулах ёстой.

**\*\*Хэрэв энэ нь таны үйл ажиллагаанд хамаарахгүй бол "Хамаарахгүй" гэсэн хэсгийг бөглөөд С шалгуур үзүүлэлт руу шилжинэ үү\*\***

Шаардлагад нийцсэн байдлыг дараах байдлаар илэрхийлнэ:

|              |  |
|--------------|--|
| Биелсэн      | Нөлөөг бууруулах арга хэмжээ авч байгаа бөгөөд бусад байгаль орчны эрсдэлийг тооцоолж, бууруулсан байна. |
| Хэрэгжиж буй | Нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох, авах ажил хийгдэж байна.                                  |
| Биелээгүй    | Нөлөөг бууруулах ямар нэгэн ажил хийгээгүй байна.  |

C2: Та байгаль орчны өндөр ач холбогдолтой газруудад үзүүлэх нөлөөллийг бууруулах, түүнчлэн одоо байгаа үйл ажиллагаанаас үүдэн бий болсон байгаль орчны бусад эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч байгаа юу?

Биелсэн

Хэрэгжиж  
буй

Биелээгүй

Хамаарахгүй

*Хариултаа энд тайлбарлана уу. Шаардлагатай хэсэгт энэ чиглэлээр ажиллах зөвшөөрлийг харуулсан лицензийн хуулбарыг, нөлөөллийг бууруулах арга хэмжээний баримт бичгийн хамт хавсралт болгон оруулна уу.*

C2a: Танд уул уурхайн үйл ажиллагаанаас газар, усны доройтолд үзүүлэх нөлөөллийг бууруулах, хүрээлэн буй орчны экосистемийг хамгаалах, биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөө, ойн хомсдолыг багасгахын тулд ямар арга хэмжээ авахаа тайлагнах, мөн тухайн орон нутгийн иргэдэд зориулсан экосистемийн үйлчилгээг хамгаалах тухай холбогдох байгаль орчны байгууллагатай хамтран боловсруулсан төлөвлөгөө бий юу (бичгэн хэлбэрээр)?

Биелсэн

Хэрэгжиж  
буй

Биелээгүй

Хамаарахгүй

*Хариултаа энд тайлбарлана уу. Шаардлагатай бол төлөвлөгөө болон төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай бэлтгэсэн аливаа тайланг хавсаргана уу.*

#### IV. Мэдэгдлийг баталгаажуулж гарын үсэг зурах

Би олборлолтын үйл ажиллагааныхаа тухай тавьсан дээрх асуултуудад үнэн зөв хариулсан бөгөөд баталгаа нотолгоотой гэдгийг батлан мэдэгдэж байна.

|   |
|---|
|   |
|   |
| ГАРЫН ҮСЭГ  |
|   |
|   |
| ОВОГ, НЭР, АЛБАН ТУШААЛ, ҮНЭМЛЭХИЙН ДУГААР, ОГНОО |

## ХАВСРАЛТ I: Эрсдэл ба эрсдлийг бууруулах төлөвлөгөө

| Шалгуур үзүүлэлт<br>(тайлбар)   | Үлдсэн эрсдэлүүд   | Эрсдлийг бууруулах<br>төлөвлөгөө   |
|---|--|--|
| <p><b>Жишээ:</b> Шалгуур үзүүлэлт В: уугуул иргэд, тэдний нутаг дэвсгэр, нөөц баялаг, соёлын өвийн дурсгалт газруудыг хүндэтгэн, компанийн уул уурхайтай холбоотой үйл ажиллагааны нөлөөнд шууд болон шууд бусаар өртсөн уугуул иргэд энэхүү бодлогын талаар мэдэж байх тухай амлалтаа олон нийтэд нээлттэй бичгээр илэрхийлсэн мэдэгдэл.</p> | <p><b>Жишээ:</b> Бидэнд олон нийтэд нээлттэй, хүндэтгэн үзсэн амлалтын бичгэн мэдэгдэл хараахан байхгүй байна.</p> | <p><b>Жишээ:</b> [Сар, өдөр, жил] гэхэд бид хүндэтгэх тухай амлалт мэдэгдлээ бичиж бэлтгэн олон нийтэд хуваалцсан байна.</p> |
|   |  |  |
|   |  |  |
|   |  |  |
|   |  |  |

## ХАВСРАЛТ II: Зөвлөж буй хавсралтуудын жагсаалт

Доорх баримт бичгүүд нь planetGOLD тайланг дэмжих хавсралтууд болно. Зөвшөөрөгдсөн бусад хэлбэрүүдэд: WhatsApp аудио, видео болон ахиц дэвшлийг харуулсан зураг болон бусад баримтууд орно.

Шалгуур үзүүлэлт А: Мөнгөн усгүй баяжуулах ба химийн бодис, хог хаягдлын менежмент (цианид, мөнгөн ус агуулсан хаягдал)

- Байгууламж нь мөнгөн усгүй технологи ашигладаг, мөнгөн усаар бохирдсон хаягдлыг дахин баяжуулахад цианид ашигладаггүйг батлах технологийн схем, зураг гэх мэт.
- Мөнгөн усаар бохирдсон хаягдлыг зөвхөн цианидаар уусган баяжуулахаас өмнө агуулагдаж буй мөнгөн усыг саармагжуулдаг баяжуулах цехүүдэд худалдсан тухай бүртгэл.
- [Хаягдал дахин баяжуулдаг цех/байгууламжийн хувьд] Хаягдлыг мөнгөн усгүй байлгах журам эсвэл уусган баяжуулахаас өмнө мөнгөн усыг саармагжуулан арилгах үйл явц, мөнгөн усны менежментийн төлөвлөгөөний тодорхойлолт.

Шалгуур үзүүлэлт Б: Уугуул иргэдийн амьдрал болон эрхийг хүндэтгэх

- Амлалтаа олон нийтэд хүргэх мэдэгдэл
- Уугуул иргэдийг тодорхойлоход тусалж зөвлөлдсөн этгээд болон ашигласан аргуудын тодорхойлолт
- Ийм нөлөөлөлд өртсөн иргэдийн төлөөллийн байгууллагуудтай харилцах бичгэн төлөвлөгөө
- Хэлэлцүүлэг болон бусад хэлбэрийн зөвлөгөөний баримт бичиг (жишээлбэл, хурлын тэмдэглэл).
- Боломжит нөлөөллийг (сөрөг эсвэл эерэг) тодорхойлоход ашигласан аргуудын тодорхойлолт ба/эсвэл тайлангууд
- Сөрөг нөлөөллийг бууруулах нотолгоо

Шалгуур үзүүлэлт С: Байгаль орчныг хамгаалах

- Үйлдвэрлэлийн бүсэд хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн нотлох баримт бүхий лиценз (боломжтой бол тусгай хамгаалалтын бүс нутагт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл орно)
- Усны хяналтын мэдээлэл
- Нөхөн сэргээлтийн бичсэн төлөвлөгөө
- [Тусгай хамгаалалтын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй байгууламжууд]
  - Уул уурхайн үйл ажиллагааны газар усны доройтолд үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө (бичгээр)
  - Орчны байгалийн тогтолцоог хамгаалах, биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөөлөл, ойн хомсдолыг багасгах, орон нутгийн иргэд, хамт олонд зориулсан экосистемийн үйлчилгээг хамгаалахад чиглэсэн арга хэмжээний талаар тайлан гаргах

### ХАВСРАЛТ III: Уугуул иргэдийг хүндэтгэх тухай мэдэгдэл

Бичил уурхайн байгууллага нь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан уугуул иргэдийн эрхийг хамгаалах тухай тунхаглалд заасанчлан тухайн нутгийн уугуул иргэдийн эрх, ашиг сонирхол, газар, устай холбогдсон тусгай холбоо, өв соёл болон хэтийн төлөвийг хүндэтгэн үзэхээ батлан мэдэгдэж байна.

|   |
|---|
|   |
|   |
| ГАРЫН ҮСЭГ  |
|   |
| ОВОГ, НЭР, АЛБАН ТУШААЛ, ҮНЭМЛЭХИЙН ДУГААР, ОГНОО |